

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: 1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоорой.

1. Нийгэмшлийн үйл явцыг социологийн шинжлэх ухааны үүднээс тодорхойлсон нь аль вэ? /1оноо/
 А. Нийгэмшил нь соёлыг нэг үеэс нөгөө үед дамжуулан өвлүүлэх үйл явц
 В. Нийгэмшил нь бие хүний хөгжил төлөвшлийн үйл явцын нэг бүрэлдэхүүн хэсэг
 С. Хүнийг нэг талаас нийгмийн үүрэгт сургах, нөгөө талаас хувь хүнд нийгмийн дүр төлөвших үйл явц
 D. Хувь хүнийг нийгмийн харилцаанд оролцоход сурах, сургах үйл явц
 E. Хүн соёлд дасан зохицож нийгмийн бүрэн эрхт гишүүн болж төлөвших үйл явц
2. Нийгмийн гажуудлын төрөлд аль нь орох вэ? /1 оноо/
 А. Жагсаал цуглаан хийх
 В. Үр хөндүүлэх
 С. Тамхи татах
 D. Шоронд хоригдох.
 E. Байцаалт өгөх
3. ... нь нийгмийн дэд тогтолцоо бөгөөд нийгмийг оршин тогтнох, амьдран хөгжихөд туслан үйлчлэх чиг үүрэгтэй. /1 оноо/
 А. Соёл
 В. Нийгмийн институт
 С. Иргэний нийгэм
 D. Төр
 E. Нийгмийн харилцаа
4. Нийгэмшлийн гол хүчин зүйлсийг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/
 А. Гэр бүл
 В. Үе тэнгийнхэн
 С. Сайн дурын нийгэмлэг
 D. Сургууль
 E. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
5. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. /1 оноо/

1. Дан хаалттай гэр бүл	а. Эхнэрүүд нь заримдаа нэг орон байранд амьдардаг ч голдуу тус тусдаа гэрийн аж ахуйг хөтөлдөг
2. Полиандр	б. Гэр бүлийн бие даасан чанар өндөрсөж, хүмүүжилд илүү анхаарал тавьдаг гэр бүл
3. Моногами	с. Нэгээс илүү эмэгтэйтэй эсвэл эрэгтэйтэй нэгэн зэрэг гэрлэснийг хууль бус үздэг гэр бүлийн хэлбэр
А. 1a2b3c В. 1c2b3a С. 1a2c3b D. 1b2a3c E. 1c2a3b	

6. Энхбат төрсөн нутагтаа физикийн багшаар ажиллаж байгаад 5 жилийн дараа сургуулийн захирлаар томилогджээ. Энэ нь нийгмийн шилжих хөдөлгөөний аль хэлбэрт хамаарах вэ? /2 оноо/
 А. Үе хоорондын шилжих хөдөлгөөн
 В. Бүлгийн шилжих хөдөлгөөн
 С. Бүтцийн шилжих хөдөлгөөн
 D. Хүн амын шилжих хөдөлгөөн
 E. Үеийн доторх шилжих хөдөлгөөн
7. Нийгэм хэмээх ойлголтын тодорхойлолт аль нь вэ? /2 оноо/
 А. Өөрийн гэх нутаг дэвсгэрийн хязгаар төр засаг, байгууллага бүхий тухайн нийгэм хүмүүсийн бие даан оршин амьдарч буй онцлог нутаг
 В. Засаглал удирдлагын тодорхой дэг журам бүхий тухайн улс орон, нийгмийг удирдах улс төрийн цөм байгууламж
 С. Тодорхой улс орон ард түмний түүхэн хөгжлийн шатан дахь нийгэм улс төр эдийн засаг, соёлын тогтвортой хамтын ажиллагаа харилцан үйлчлэл, хэрэгцээ сонирхлын ялгаа зөрчилдөөн бүхий хүмүүсийн нэгдэл
 D. Нийгмийн хуучин байгуулал шинэ байгуулалд эрс шилжилт хийж, чанарын үсрэлтэнд хүрэх ойлголт
 E. Хүний амьдралын нөхцөл чанар дээшлэх гэх зэрэг томоохон хэмжээний эерэг үр дагаврууд
8. Шашны номлолоор зөвтгөгдөн хувийн байр суурийг өөрчлөх ямар ч боломжгүй давхраажилтын тогтолцоо аль нь вэ? /1 оноо/
 А. Анги
 В. Каст
 С. Нийгмийн ялгарал
 D. Боолчлол
 E. Язгуур

9. Аль нь олдмол статус вэ? /1 оноо/
 А. Ардын уран зохиолч Бавуугийн Лхагвасүрэн айлын ганц хүү.
 В. Би айлын отгон охин
 С. Мөнх 12-р ангид суралцахын зэрэгцээ FM радиогийн хөтлөгчөөр ажилладаг.
 D. Ерөнхий сайд А.Амар хохь тайжийн хүү ажээ.
 E. Дуучин С.Жавхлан Увс аймгийн уугуул.
10. Нийгмийн халамжийн үйлчилгээ нь: -нийгмийн хөгжлийн үйлчилгээ;-халамжийн үйлчилгээ гэсэн хоёр төрөлтэй. Дараах өгөгдлийн аль нь хөгжлийн үйлчилгээнд хамаарах вэ? /2оноо/
 А. Бие даан амьдрах чадваргүй ахмад настныг байрлуулан асрамжлах
 В. Бага орлоготой өрхүүд хамтран хүнсний ногоо тариалах
 С. Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн үйлчилгээ
 D. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрах үйлчилгээ
 E. Боловсрол эзэмшихэд нь туслах
11. “Амьтны амь бүү хороо, шударга бай...” гэх мэт ёсыг захирамжлан тогтоох нь ... юм. /2 оноо/
 А. Ёс суртахууны онцлог В. Ёс суртахууны шинж С. Ёс суртахууны нөлөөлөл
 D. Ёс суртахууны шаардлага E. Ёс суртахууны бэлгэ тэмдэг
12. Ёс суртахууны төлөвшүүлэх үүрэг аль нь вэ? /1оноо/
 А. Хувь хүний үйл ажиллагааг бусад хүмүүс болон нийгмийн эрх ашигт нийцүүлэн чиглүүлж байдаг.
 В. Ёс суртахууныг өөриймшүүлснээр хүмүүс үйлдэл, үйл ажиллагаагаа хянаж, удирдаж байдаг.
 С. Ёс суртахуунаар дамжин хүмүүс дүрэм, журам, нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар мэдлэг эзэмшдэг.
 D. Хүмүүс өөрийгөө авч явах чиг баримжаа эзэмшиж байдаг.
 E. Өөрийн болон бусдын ёс суртахууны төлөвшилд үнэлгээ өгч байдаг.
13. Нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж өмнө нь тогтвортой байсан зан суртахууны үнэлэмж, үнэт зүйлс задарсныг юу гэж нэрлэх вэ? /1 оноо/
 А. Соёлын шок В. Сөрөг соёл С. Соёлын гажилт
 D. Дэд соёл E. Релятивизм
14. Ургийн бичиг хөтөлж үр хойчдоо үлдээх нь соёлын аль элементийг илэрхийлж байна вэ? /1 оноо/
 А. Заншил В. Зуршил С. Нийтийн соёл D. Уламжлал E. Үнэлэмж
15. Соёлыг төлөв байдлаар нь ... гэсэн хоёр хэсэгтэйгээр авч үздэг. /1 оноо/
 А. Соёлын динамик, соёлын статик В. Соёлын нэвчилт, соёлын тархалт
 С. Соёлын олон янз байдал, соёлын зөрчил D. Эдийн соёл, оюуны соёл
 E. Соёлын нэгдэл, соёлын тархалт
16. Монгол хүний онцлон эрхэмлэдэг зүйл нь бүс юм. Бүсийг хүний сүлд хийморь гэж үзнэ. Харин гутал, өмдөн дээрээ тавих буюу бүсний дээгүүр алхах, гишгэхийг бузартана гэж цээрлэдэг. Дараах ойлголтуудаас уг өгөгдөлд хамааралгүй нь аль вэ? /2 оноо/
 А. Хэм хэмжээ В. Ёслол С. Бэлгэдэл D. Заншил E. Уламжлал
17. Бүх л соёлд нэгэн адил хамаардаг шинж чанар, хэм хэмжээ, дүрэм журам, үнэт зүйлсийг соёлын.....гэнэ. /1оноо/
 А.Этноцентризм В.Релятивизм С.Универсаль D. Плюрализм E.Дуализм
18. Үнэлэмжийг түвшингээс нь хамааруулан зөв дарааллаар ангилсан нь аль вэ? /2 оноо/
 А. Нийт хүн төрөлхтний-тухайн нийгмийн-угсаатны-анги бүлгийн-гэр бүлийн-хувь хүний;
 В. Нийт хүн төрөлхтний-тухайн улсын-үндэстний-анги бүлгийн-гэр бүлийн-хувь хүний;
 С. Нийт хүн төрөлхтний-тухайн нийгмийн-ястны-анги бүлгийн-гэр бүлийн-хувь хүний;
 D. Нийт хүн төрөлхтний-тухайн нийгмийн-үндэстний-нийгмийн анги, бүлгийн-гэр бүлийн-хувь хүний;
 E. Нийт хүн төрөлхтний-тухайн нийгмийн-овог аймгийн-анги бүлгийн-гэр бүлийн-хувь хүний;

19. Соёлыг социологийн хандлагаар хэрхэн тодорхойлдог вэ? /3 оноо/
 А. Соёлыг хүний мөн чанарын илэрхийлэл болох талаас нь тайлбарладаг.
 В. Нийгмийн аж төрөх ёс, зохион байгуулалтыг бүрдүүлэгч хүчин зүйл гэдэг талаас нь тайлбарладаг.
 С. Янз бүрийн ард түмний домог, аман зохиол зэргийг харьцуулан судлах замаар тайлбарладаг.
 D. Соёлын утга санаа нь хүний гэх зүйлийг амьтны гэх зүйлээс ялгах хязгаар болж өгдөг гэж үздэг.
 E. Соёл бол өв уламжлан авсан бүтээл, юмс, үзэл санаа, үнэт зүйл гэж тайлбарладаг.
20. Английн эрдэмтэн А.Марш улс төрийн оролцооны хэв маягийг хэрхэн ангилсан бэ? /1 оноо/
 А. Идэвхтэй ба идэвхгүй В. Хуулийн хүрээнд, хууль бус С. Нийцтэй ба нийцгүй
 D. Сайн дурын ба албадлагын E. Ортодоксаль ба ортодоксаль бус
21. Засаглалын субъект зорилгодоо хүрэхийн тулд объектод нөлөөлөх арга хэрэгсэл аль нь вэ? /2 оноо/
 А. Засаглалын хэлбэр В. Засаглалын нөөц С. Засаглалын механизм
 D. Засаглалын хэмжигдэхүүн E. Засаглалын орон зай
22. Хууль хэлэлцэх нь улс төрийн тогтолцооны бүрдэл хэсгийн алинд хамаарах вэ? /1 оноо/
 А. Оролт В. Гаралт С. Хувиргалт D. Шаардлага E. Дэмжлэг
23. Өгөгдлийг зөв харгалзуулсан хариултыг сонгоорой. /1 оноо/
 1. Сонирхлыг илэрхийлэх а. Ардчилсан нам
 2. Сонирхлыг нэгтгэх б. Сангийн яам
 3. Сонирхлыг хэрэгжүүлэх с. Монголын оюутны холбоо
 А. 1с2а3b В. 1b2а3с С. 1с2b3а D. 1а2b3с E. 1b2с3а
24. Олон намын ач холбогдолд хамаарахгүй зүйл дурдсан бол аль нь вэ? /2 оноо/
 А. Олонхийн дэмжлэг авсан улс төрийн нам нь засаглалыг хэрэгжүүлдэг.
 В. Засаглалын тэнцвэрийг хадгалах нөхцөл бүрддэг.
 С. Олон ургальч үзлийг дэмждэг.
 D. Цөөнхийн дэмжлэг авсан нам нь эрх барьдаг.
 E. Хүний эрхийг хангадаг.
25. Саналаа нууцаар гаргах зарчим аль нь вэ? /1 оноо/
 А. Нас хүйс, яс үндэс, гарал угсаа, мэргэжил, хэл, санхүүгийн чадвараас үл шалтгаалан бүгд оролцох
 В. Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй бөгөөд санал бүр адил жинтэй байх
 С. Сонгогч ямар нэгэн дарамт шахалтгүйгээр гагцхүү өөрийн үзэмжээр саналаа өгөх явдал
 D. Сонгуулийн эцсийн үр дүн нь зөвхөн иргэдийн санал хураалтын үр дүнгээр шийдэгддэг.
 E. Сонгуульд оролцохдоо саналаа чөлөөтэй илэрхийлэх бүхий л бололцоогоор хангагдах ёстой.
26. Франц, Армен, Тайван, Финлянд улс ямар засаглалтай вэ? /2 оноо/
 А. Үндсэн хуульт хаант засаглалтай В. Парламентын засаглалтай
 С. Хэмжээт эрхт хаант засаглалтай D. Холимог засаглалтай
 E. Ерөнхийлөгчийн засаглалтай
27. Төлөөллийн ардчиллын сул тал аль нь вэ? /2 оноо/
 А. Нийгэмд улс төрийн тогтвортой байдал, дэг журмыг илүү хангадаг
 В. Нийгмийн бүлэг, давхрааны хэт ялгарал, эсвэл тэгшитгэх байдлаас нийгмийг хамгаалдаг
 С. Иргэд төрийн хэрэгт шууд оролцохгүй тул улс төрийн идэвх буурах талтай
 D. Нийгэм, улс төрийн тогтолцоог мэргэшиж, туршлагажсан хүмүүс удирдан зохион байгуулдаг
 E. Улс төрийн хариуцлагыг өндөржүүлдэг
28. Ардчилсан бус дэглэмээс ардчилсан дэглэмд шилжих үеийн дэглэм аль нь вэ? /1 оноо/
 А. Консерватив В. Либераль С. Фашист D. Охлократ E. Коммунист
29. Социал төрийн шинжид хамаарах өгөгдлийг олно уу. /3 оноо/
 А. Иргэд хуулийг заавал биелүүлэх ёстой.
 В. Иргэн төр хоёр адилхан хариуцлага хүлээнэ.
 С. Иргэдийн амьдралын наад захын баталгааг хуулиар тогтоох ёстой.
 D. Төрөөс хүний эрхийг баталгаатай хангаж эдлүүлнэ.
 E. Шүүгч зөвхөн хуульд захирагдана.

30. Үйлдвэрлэл явуулахад шаардлагатай нөөцийг худалдан авах, ашиглахтай холбоотой гарах мөнгөн төлбөрийг.....гэнэ. /1оноо/
 А. Тогтмол зардал В. Хувьсах зардал С. Үйлдвэрлэлийн зардал
 D. Шууд зардал E. Шууд бус зардал
31. Нөхөрлөл хоршооны сул талуудыг тоочихдоо хамааралгүй зүйл дурдсан бол аль нь вэ?/2 оноо/
 А. Дотоод зөрчил их
 В. Хохирлыг гишүүд тэнцүү хариуцна
 С. Бизнесийн амьдралын хугацаа богино
 D. Үүсгэн байгуулахад хуулийн талаас бүрдүүлэлт хийхэд хүндрэлтэй
 E. Гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороход хуулийн талаас нэлээд хүндрэлтэй
32. Менежментийн ухааны тодорхойлолтонд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
 А. Менежмент нь аж ахуй эрхлэн хөтлөх,жолоодох гэсэн утга бүхий англи үг
 В. Хүмүүст аж ахуйг хэрхэн удирдах талаар онолын цэгцтэй мэдлэг олгодог шинжлэх ухаан
 С. Хэрэглэгчийн эрэлтийг судлан, түүнд тохирсон бараа үйлчилгээг зах зээлд гаргах
 D. Байгууллагын зорилгод хүрэх арга замуудыг төлөвлөн зохион байгуулж хэрэгжүүлэх үйл ажиллагаа
 E. Үйл ажиллагааг удирдан зангидах зохион байгуулах урлаг
33. Маркетинг гэж чухам юу болохыг хувь хүн, аж ахуйн нэгж мэдэж байх нь ач холбогдолтой. Дараах өгөгдлөөс хувь хүнд маркетинг ямар ач холбогдолтойг илэрхийлсэн ойлголтыг олно уу. /2 оноо/
 А. Хэрэглэгчийн зан төлөв, эрэлтийг мэдрэх В. Зардлаа багасгаж, цагаа хэмнэх
 С. Зах зээлээ таньж мэдэх D. Өрсөлдөгчөө таньж мэдэх
 E. Ашиг орлогоо нэмэгдүүлэх
34. Гадаад худалдааг хязгаарлах бодлогын шалтгааныг тоочихдоо илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? /1 оноо/
 А. Улс үндэсний аюулгүй байдлыг хамгаалах В. Дотоодын эдийн засгийн салбаруудыг дэмжих
 С. Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх D. Гадаад худалдааг хамгаалах
 E. Улсын төсвийг нэмэгдүүлэх
35. Мэргэжлийн чиг баримжаа олгох болон дахин мэргэшүүлэх, чиглэлээр сургалт зохион байгуулж байгаа нь ажилгүйдлийн аль төрөлтэй тэмцэх арга вэ? /2 оноо/
 А. Шилжилтийн ажилгүйдэл В. Улирлын ажилгүйдэл С. Түр зуурын
 D. Бүтцийн E. Мөчлөгийн ажилгүйдэл
36. Өгөгдлийг холбогдох утгатай нь зөв харгалзуулна уу. /1 оноо/
 1.Хөрөнгийн бирж а.Үнэт цаасны зах зээл дээр бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах ажиллагаа
 2.Хувьцааны ханш b.Хөрөнгийн бирж дээр тогтож байгаа хувьцааны зах зээлийн үнэ
 3.Брокерийн үйл ажиллагаа c.Үнэт цаасыг худалдах, худалдан авах, бусдад шилжүүлэх гэх мэт үнэт цаасны арилжаа явагдаж байдаг газар
 А. 1b2a3c B. 1a2b3c C. 1c2b3a D.1a2c3b E. 1b2c3a
37. Хувьцааны давуу талуудыг тоочихдоо хамааралгүй зүйл дурдсан бол аль нь вэ? /2 оноо/
 А. Ногдол ашиг авах В. Ханшийн зөрүүнээс олох ашиг
 С. Ашиг их бол эрсдэл бас өндөр байж болно D. Компанийн удирдлага шийдвэр гаргахад оролцох
 E. Инфляцид өртөхгүй
38. Компани бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэр байгуулсан нь юм. /1 оноо/
 А. Капиталын экспорт В. Шууд хөрөнгө оруулалт С. Портфелийн хөрөнгө оруулалт
 D. Экспортын бодлого E. Импортын бодлого
39. Хууль, хуульчилсан актад хамаарагдах бүхий л нутаг дэвсгэр, субъектийн хүрээнд эрх зүйн шаардлагыг дагаж мөрдөх,сахих явдлыг.....гэнэ. /2 оноо/
 А. Дэг журам В. Хууль зүйн факт C. Хууль зүй D. Хууль ёс E. Шударга ёс

40. Зөв харгалзуулна уу. /1 оноо/
1. Иргэн А. Хууль зөрчсөн, урьдчилан бодож боловсруулсан, эсвэл болгоомжгүйгээс үүдэлтэй нийгмийн аюултай үйлдэл
2. Гэмт хэрэг В. Гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхийн шийдвэрээр хэрэглэж буй төрийн хуулийн албадлагын арга хэмжээ
3. Ял шийтгэл С. Тодорхой улсын нутаг дэвсгэрт оршин суугаа төрийн харьяалалд багтдаг эрх зүйн субъект
- A. 1a2b3c B. 1c2a3b C. 1b2c3a D. 1a2c3b E. 1c2b3a
41. Эрүүл мэнд, боловсрол, соёлын зэрэг төрийн суурь үйлчилгээг хүн бүрт хүргэх төрийн байгууллагын үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий албыг.....гэнэ. /1оноо/
- A. Төрийн үйлчилгээний алба B. Төрийн тусгай алба C. Төрийн захиргааны алба
D. Улс төрийн алба E. Төрийн хамгаалалтын алба
42. Төрийн албанд баримтлах зарчмуудад хамааралгүй зүйл дурдсан бол аль нь вэ? /1оноо/
- A.Төрийн алба мэргэшсэн тогтвортой байх B. Захирах захирагдах ёсыг баримтлах
C.Гадаад хэлний өндөр мэдлэгтэй байх D. Ард түмэнд үйлчлэх
E.Төрд ажиллах тэгш боломжтой байх
43. Тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодох, багшийн ёс зүйн дүрэм зөрчих, тогтоосон хугацаа хэтрүүлэн согтууруулах ундаагаар үйлчилбэл ямар төрлийн шийтгэл ногдуулах вэ? /2оноо/
- A. Торгох B. Тусгайлан олгосон эрхийг хасах
C. Хууль бусаар олсон орлого эд зүйлийг хураах D. Сануулга өгөх
E. Баривчлах
44. Холбогдох утгатай нь зөв харгалзуулна уу /1 оноо/
1. Гэм буруу А. Хууль бус үйлдэл хийсэн, бусдад хохирол учруулагч этгээд
2. Гэм буруутан В. Гэм буруутай этгээдийн хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирол
3. Гэм хор С. Гэмт этгээд өөрийн үйлдлийн бурууг ойлгон ухаарах байдал
A.1c2b3a B.1b2a3c C.1c2a3b D.1a2b3c E.1b2c3a
45. Хүний эрхийн талаар олсон ололт амжилтаа бататгаж, ахёёёао í ü хүний эрхийн талаар төрийн..... үүрэг юм. /1оноо/
- A. Хүндэтгэх B. Албан тушаал ахиулах C. Хангах D. Хамгаалах E. Ахиц дэвшил гаргах
- 46.Хүний эрхийн үндэсний комисс нь бие даасан, хараат бус хүний эрхийн үндэсний байгууллага юм. Ёомиссын үйл ажиллагаанд хамааралгүй өгөгдлийг олно уу. /2 оноо/
- A. Хүний эрхийн олон улсын гэрээнд нэгдэн орохыг дэмжих, олон нийтэд сурталчлах
B. Хүний эрхийн боловсрол олгох
C. Хууль тогтоох замаар хүний эрхийг хангах бодлого эрх зүйн орчинг бүрдүүлэх
D. Судалгаа, хяналт шалгалт явуулах
E. Хүний эрхийн зөрчлийн талаарх гомдлыг шалгаж шийдвэрлэх
47. Банк, санхүүгийн байгууллагатай харилцахад ямагт иргэний үнэмлэх төрлї ий гэрчилгээг шаарддаг. Үүнд хамаарах өгөгдлийг олно уу. /2 оноо/
- A. Хэрэглэгчийг хамгаалах B. Өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой
C. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих D. Аюулгүй байдал хангах
E. Өбөөеёі үдгээдийн хооронд үүссэн харилцааг зохицуулах
48. Улс төрийн албан тушаалтан аль нь вэ? /2оноо/
- A. Бүх шатны шүүгч, прокурор B. Монгол банкны ерөнхийлөгч
C. Аймаг,нийслэл,сум дүүргийн ИТХ болон гүйцэтгэх албан тушаалтнууд
D. Монгол Улсын Их хурлын дарга, гишүүд E. Улсын харьяаны сургуулийн багш
49. Аль нь НҮБ-ын албан ёсны хэл биш вэ? /1 оноо/
- A. Араб B. Хятад C. Англи D. Турк E. Орос

50. нь дэлхий дахины харилцаанд оролцогчдын хооронд бий болсон эдийн засаг, улс төр, нийгмийн болон эрх зүй, дипломат, батлан хамгаалахын мөн соёлын харилцан холбоо бүхий систем юм. /1оноо/

- A. Олон улсын харилцааны субъект
- B. Олон улсын байгууллага
- C. Олон улсын харилцааны систем
- D. Олон улсын харилцааны үндсэн хэлбэр
- E. Олон улсын харилцаа

51. НҮБ –ийн дүрмийн үндсэн зарчмуудад хамааралгүй өгөгдлийг олно уу. /1оноо/

- A. Энх тайван, аюулгүй байдлыг сахих
- B. Үндэстэн хооронд найрамдалт харилцааг хөгжүүлэх
- C. Улс орнуудын дотоод бодлогод нөлөөлөх
- D. Дэлхий нийтийн чанартай асуудлуудад хамтран ажиллах
- E. Үндэстнүүдийн үйл ажиллагааг нэгтгэх төв байх

52. Зөв харгалзуулна уу. /1оноо/

1. Парламентын дипломат	A. Олон улсын харилцаанд оролцогч субъект бусад улсын өмнө хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд үүсэх хууль зүйн үр дагавар
2. Ардын дипломат	B. Олон улсын харилцаанд улс орнуудын хууль тогтоох байгууллага болсон парламент, түүнд олон нийтээс сонгогдсон төлөөлөгчид болох парламентын гишүүд болсонтой холбогдож гарсан ойлголт
3. Олон улсын эрх зүйн хариуцлага	C. Мэргэжлийн дипломатаас ялгаатай бөгөөд янз бүрийн улс орны жирийн иргэдийн хоорондын харилцаагаар илэрдэг олон улсын бодлогын шинжтэй үзэгдлийг тэмдэглэсэн ойлголт.

- A.1a2c3b
- B.1b2c3a
- C.1a2b3c
- D.1c2a3b
- E.1b2a3c

53. Дэлхийн улс орнууд хоорондоо төр, засгийн газрын түвшинд элчин төлөөлөгч солилцож, яриа хэлэлцээр явуулж гарын үсгээ зурж баталгаажуулж байдаг нь.....харилцаа юм. /1оноо/

- A. Олон улсын эдийн засгийн харилцаа
- B. Олон улсын соёлын харилцаа
- C. Олон улсын улс төрийн харилцаа
- D. Олон улсын технологийн харилцаа
- E. Олон улсын хүмүүнлэгийн харилцаа

54. Хоёр улс өөрсдийн нутаг дэвсгэрийн усанд нөгөө этгээд нь загас агнахыг зөвшөөрсөн гэрээ байгуулжболно. Энэ нь олон улсын ямар хэм хэмжээ болохыг тодорхойлно уу. /2оноо/

- A. Хатуу буюу императив
- B. Уян хатан буюу диспозитив
- C. Хориглосон хэм хэмжээ
- D. Үүргийн хэм хэмжээ
- E. Зарчмын хэм хэмжээ

55. Монгол улсын гадаад бодлогын зорилтод аль нь нийцэхгүй вэ? /1оноо/

- A. Хүн төрөлхтний хөгжлийн жамыг даган бүх улс оронтой найрсаг харилцаатай байх
- B. Олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх
- C. Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бат найдвартай хангах
- D. Улс төр, эдийн засаг болон бусад ашиг сонирхлын шүтэлцээ бүхий харилцаа
- E. Социализмын эрх ашгийг өмгөөлөн хамгаалах

56. Ази, Номхон далайн бүс нутгийг бүхэлд нь хамарсан өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг хоёр тивийн яриа хэлэлцээний механизм аль нь вэ? /1 оноо/

- A. АСЕАН
- B. АСЕМ
- C. АПЕК
- D. АРФ
- E. ШХАБ

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: 1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож хариуг аэглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу.

a	Амьдралын чанарын индекс	1	Дундаж наслалт, боловсролын түвшин, нэг хүнд ногдох ДНБ
b	Тогтвортой хөгжил	2	Нөөцийн тоо хэмжээний болон бүтээмжийн өсөлтөөр хангагдана.
c	Үйлдвэрлэлийн хүчин зүйл	3	Эдийн засаг, байгаль орчин, нийгмийн байдлыг адил авч үзнэ.
d	Хүний хөгжлийн индекс	4	Насжилт, нялхсын эндэгдэл, бичиг үсэгт тайлагдсан байдал
e	Эдийн засгийн өсөлт	5	Газар, капитал, хөдөлмөр, ур чадвар

2.2. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу.

a	Нийгмийн статус	1	Нийгмийн гишүүд хувийн болон нийгмийн шинжээрээ зааглагдах
b	Нийгмийн харилцан үйлдэл	2	Нийгмийн тогтолцоон дахь байрсуурь, түүнд хамаарах эрх, үүрэг, бусдын зүгээс хандах хандлага
c	Нийгмийн институт	3	Нийтлэг сонирхол, үнэлэмжтэй хүмүүсийн нэгдэл
d	Нийгмийн ялгарал	4	Хоёр ба түүнээс олон хүмүүсийн хоорондын харилцаа
e	Нийгмийн бүлэг	5	Хамтын сонирхол, хэрэгцээ, үнэлэмжийг хангахад чиглэсэн зохион байгуулалт, нийгмийн үйлдлийн хэм хэмжээ, тогтсон хэлбэрүүдийн цогц

2.3. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу.

a	Тэмдэг	1	Оюуны соёлд хамгийн анх үүссэн бөгөөд орчин үед ч оршин буй.
b	Хэл	2	Хүний танин мэдэх үйл ажиллагааны үр дүн
c	Мэдлэг	3	Хүний бүтээн хэрэглэж байгаа тэмдгийн ил эсвэл далд утга
d	Бэлгэдэл	4	Семиотикийн шинжлэх ухааны судлах зүйл
e	Домог	5	Хүний оюуны ертөнцийг илэрхийлэгч, мэдээллийг бүтээгч, хадгалагч, дамжуулагч

2.4 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу.

a	Санал	1	Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас иргэдийн эрх ашиг, сонирхол зөрчигдсөн болон бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлт
b	Гомдол	2	Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэд байгууллагаас гаргаж буй шаардлага
c	Мэдэгдэл	3	Маргаж байгаа болон зөрчигдсөн эрх ашиг, сонирхлоо хамгаалуулахын тулд хуулиар тогтоосон журмын дагуу шүүхэд хандаж хариуцагчид тавьсан шаардлага
d	Өргөдөл	4	Захиргааны байгууллагын буруугаас иргэдийн болон аж ахуйн нэгжийн эрх зөрчигдөж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр хандаж буй харилцааны хэлбэр
e	Нэхэмжлэл	5	Төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх, талаар гаргасан хүсэлт бөгөөд аливаа асуудлыг оновчтой буюу зохистой байдлаар шийдвэрлүүлэх зорилготой